



БАГАХАНГАЙ ДУУРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 8/26

Улаанбаатар хот

Г Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, Агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дэх хэсэг, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/158 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлд автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр (цаашид албан татвар, төлбөр гэх) хураах тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, шаардагдах хөрөнгийн төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дүүрэгт бүртгэлтэй бүх төрлийн тээврийн хэрэгслийн албан татвар, төлбөр хураах ажлыг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулж, орлогыг төсөвт төвлөрүүлэн, албан татвар, төлбөрөө төлөөгүй тээврийн хэрэгсэл эзэмшиж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дутуу төлөлтийг хураан барагдуулах, хариуцлага тооцох хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т даалгасугай.

3. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доор дурдсан байгууллага, албан тушаалтанд даалгасугай.

3.1. Албан татвар, төлбөр хураах ажлыг нутаг дэвсгэрт автотээврийн хэрэгсэл эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын бүрэн хамруулан, татварт хамрагдалтын түвшинг өмнөх жилээс нэмэгдүүлэх.

3.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын албан татвар, төлбөрийг хуулийн хугацаанд Нийслэлийн замын сангийн дансанд төвлөрүүлэх, Нийслэлийн 2024 оны төсвийн орлогын төлөвлөгөөний сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах.

4. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доор дурдсан байгууллага албан тушаалтанд үүрэг болгосугай.

4.1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 28 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлд автотээврийн хэрэгслийн бүртгэл, төлбөрийн тогтолцоог шинэчилэн нэвтрүүлэх журам"-ын 3.4-т заасны дагуу автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, төлбөр хураах ажлыг зохион байгуулж, тухайн сардаа албан татвар, төлбөр төлөөгүй автотээврийн хэрэгсэлд хяналт тавьж, замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх арга хэмжээ авч ажиллахыг Татварын хэлтэс (Х.Анхбаяр), Цагдаагийн хэлтэс (Т.Лхагвасүрэн), Замын цагдаагийн хэсэг (Д.Билгээ)-т

4.2. Гудамж, замын хяналт шалгалт болон тухайн сардаа албан татвар, төлбөрөө төлөөгүй, техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй замын хөдөлгөөнд оролцож байгаа автотээврийн хэрэгслийг хяналтын камерын тусlamжтайгаар илрүүлж, зохих байгууллагад шилжүүлэн, холбогдох газруудыг мэдээллээр хангаж, хамтран ажиллахыг Цагдаагийн хэлтэс (Т.Лхагвасүрэн), Замын цагдаагийн хэсэг (Д.Билгээ)-т

4.3. Дүүргийн төр захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллагын албан татвар, төлбөрийг хуулийн хугацаанд Нийслэлийн замын сангийн дансанд төвлөрүүлэхийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Мягмарсүрэн), Татварын хэлтэс (Х.Анхбаяр)-т

5. Албан татвар, төлбөр хураах ажиллагааг зохион байгуулахад шаардагдах шатахууны зардал 714,000 (Долоон зуун авсан дөрвөн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

6. Албан татвар, төлбөр хураах ажлыг зохион байгуулж тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээ "smartcar.mn" систем, Татварын удирдлагын нэгдсэн систем "e-tax.mta.mn, i-tax.mta.mn" систем, "и-баримт" гар утасны апликэйшн, гэрэгээ киоск төхөөрөмж ашиглан албан татвар, төлбөр төлөх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилж албан татвар, төлбөр төлөгчдөд үйлчилгээг хөнгөн шуурхай үзүүлэн, дүүрэгт явуулын оношилгоо ирүүлэн аж ахуй нэгж, байгууллага болон иргэдийн бүх тээврийн хэрэгслийг хамруулан ажиллахыг ажлын хэсэг (Б.Болормаа)-т үүрэг болгосугай.

7. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан "Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах талаар авах зарим арга хэмжээний тухай" Дүүргийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/45 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

А.СУХБОЛД



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 12 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар,
авто замын төлбөр, агаарын бохирдлын төлбөр хураах ажлыг
зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн
дарга:

Б.Болормаа

Засаг даргын Эдийн засаг,
нийгмийн хөгжлийн асуудал
хариуцсан орлогч
Засаг даргын Тамгын
газрын Санхүү, төрийн
сангийн хэлтсийн дарга
Татварын хэлтсийн дарга
Цагдаагийн хэлтсийн дарга,
Цагдаагийн хурандаа
Замын цагдаагийн хэсгийн
дарга цагдаагийн дэд хурандаа
1-р хорооны Засаг дарга
2-р хорооны Засаг дарга

Гишүүд:

Ц.Мягмарсүрэн

Х.Анхбаяр
Т.Лхагвасүрэн
Д.Билгээ
Н.Нямзав
Б.Батзориг

Нарийн бичгийн
дарга

С.Бүрэнтөгс

Татварын улсын байцаагч

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны дугаар сарын -ны өдрийн дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Материалын нэр	Нийт явах километр	Хэмжих нэгж	100 км-т зарцуулах хэмжээ	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шатахуун (АИ92)	2000	Литр	15	300	2380	714,000
Нийт							714,000